



ГХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭЖ БУЙ
АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА,
ИРГЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017. 02. 15 № 02-01/576 .
танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 19 дүгээр “Хүнсний аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” тогтоолд хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдан борлуулагч, түүгээр үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж иргэний үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж стандартын дагуу явагдаж буй эсэх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авч ажиллуулах талаар заасан байна.

Иймд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, иргэд сар шинийн баярыг угтан хүнсний үйлдвэрлэлийн өөрт хамаарах үе шат бүрд дотоодын хяналт тавьж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулан ажиллах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг мэдэгдье. Үүнд:

1. Үйлдвэрлэлд хэрэглэх мах махан бүтээгдэхүүний гарал үүсэл тодорхой байх, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан баталгаажилттай түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах;
2. Хүнсний үйлдвэрлэлийн бүх үе шатанд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлуудыг нэвтрүүлэх;
3. Үйлдвэрлэлд мөрдөх технологийн заавар, жор орцын нормыг бүтээгдэхүүн тус бүрд баталгаажуулж, жор орц, технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, угаалга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хяналт тавин бүртгэл хөтлөх;
4. Хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, бүртгэл хөтлөх аргачлалын дагуу бүртгэлжүүлж хэвших;
5. Хүнсний чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авахдаа “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам”-ыг мөрдлөг болгох, буцаан авсан, устгасан бүтээгдэхүүнийг баримтжуулж устгах, акт бичиг баримтыг хадгалах;
6. Хүнстэй харьцагчид хувийн ариун цэврийг дээд зэргээр сахих, ажиллагсдыг

1150500774

эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд заасан хугацаанд хамруулах;

7. Бэлэн бүтээгдэхүүний шошгонд мэдээллийг бүрэн тусгах, шошгын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх;

8. Бүтээгдэхүүнийг их хэмжээгээр үйлдвэрлэн хадгалж, худалдааны сүлжээнд гаргах өдрийн огноог үйлдвэрлэсэн огноо мэтээр шошгонд бичихийг хориглох;

9. Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмыг хэрэгжүүлж ажиллах /дэлгэрэнгүй мэдээллийг ub.inspection.gov.mn –с авах/;

10. Дотоод хяналтын журмыг Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам”-д нийцүүлж, түүний хэрэгжилтэнд хяналт тавин болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах нь зүйтэй.

ДАРГА



Л.ЭРДЭНЭЧУЛУУН